



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 4 сарын 12 өдөр

Дугаар 72

Улаанбаатар хот

### “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.5, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, 63 дугаар зүйлийн 63.1.5, Хорооны 2015 оны 406 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай зарим үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэх журам”-ын 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус олгосугай.

2. Энэ тогтоолын 1-д заасан тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ш.Лхагва/-д үүрэг болгосугай.

1/ Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн, үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн системийн тасралтгүй байдлыг хангаж, эрсдэлийг хянаж ажиллах;

2/ Хууль тогтоомжид заасны дагуу зохих өөрчлөлтийг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэх.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

00153